**НИЙСЛЭЛИЙН**
**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 16 өдөр — Дугаар А/99 — Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сар шинийн баярын өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байранд хариуцлагатай жижүүрээр ажиллах хуваарийг хавсралтаар батлсугай.

2. Баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэхдээ нутаг дэвсгэрийн байгууллагуудын эргүүл, жижүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллага албан тушаалтан, Нийслэлийн шуурхай албаны “11-310005” дугаарын утсанд мэдээлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай эргүүл жижүүрүүдэд үүрэг болгосугай.

4. Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нэмэгдэл хөлс олгох эсхүл нөхөн амруулахыг холбогдох хэлтэс, албадын дарга нарт зөвшөөрсүгэй.

5. Баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүрүүд хэрхэн ажилласан талаарх дүн мэдээг нэгтгэж, дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ж.АЛДАРЖАВХЛАН

1707200093

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023оны
..02 дугаар..... сарын ...16...-ны өдрийн
А/99 дугаар.... захирамжийн хавсралт

## ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР ХИЙХ АЛБАН ХААГЧДЫН НЭР, ЦАГИЙН ХУВААРЬ

| д/д | Нэр | Хэлтэс, алба | Өдөр, гариг | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Утас | Гарын үсэг | Хяналт тавих албан тушаалтны нэр | Утас |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1. | О.Мөнгөншагай | ТГУХ | II/20 | 21:00 | II/21 09:00 | 99178551 | | Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга Л.Отгонбаяр | 88773195 |
| 2. | Т.Райса | ХЭЗАХ | II/21 | 09:00 | 21:00 | 99967684 | | Төрийн захиргааны удирдлагын хэлстийн ахлах мэргэжилтэн Ч.Ариунжаргал | 88016365 |
| 3. | Ө.Жаргалсайхан | ХХҮХ | II/21 | 21:00 | II/22 09:00 | 89903162 | | | |
| 4. | Б.Мархагүл | ХЭЗАХ | II/22 | 09:00 | 21:00 | 99120648 | | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Цогзолмаа | 99114608 |
| 5. | Г.Энх-Амгалан | ААӨХ | II/22 | 21:00 | II/23 09:00 | 80075558 | | | |
| 6. | Ц.Энхсаруул | НБХ | II/23 | 09:00 | 21:00 | 99022313 | | Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Л.Саруултуяа | 99003381 |
| 7 | О.Ариунболд | ЦШ | II/23 | 21:00 | II/24 09:00 | 99010419 | | | |